



СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-2223

2022.01.07 № 01/21
танай _____ -ны № _____

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**

Аймгийн хэмжээнд Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаатай холбогдуулан дараах асуудлуудад анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгож байна. Үүнд:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг тус хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдэд ашиглуулах.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан аж ахуй нэгжийн хүсэлтийг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтын дагуу сум, орон нутгийн хэрэгцээг үндэслэж, Ашигт малтмал, газрын тосны газрын дүгнэлт бүхий га, талбайд зөвхөн боломжтой эсэх талаар хэлэлцүүлэн санал ирүүлэх.

3.Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргасан тохиолдолд уг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах, нөхөн сэргээлтийг хийлгэж хуулийн дагуу арга хэмжээг авч ажиллах.

4.Аймгийн хэмжээнд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдтэй байгуулж буй бүх төрлийн гэрээний хууль, эрх зүйн үндэслэлд хяналт тавих, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тухай бүр зохион байгуулж гэрээ, гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг хагас, бүтэн жилээр тайлагнах

5.Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, 38.3, 38.4 дэх заалтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.



АЛХАГВАДОРЖ

430810010